

ШАРГА СУМД 2019 ОНЫ 2 ДУГААР САРД БОЛСОН
ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ

2019.02.26

Баянгол

УЛС, АЙМАГ, СУМЫН АВАРГА МАЛЧИД ТОДОРЛОО

Энэ онд **аймгийн аварга малчнаар** Баянгол багийн малчин Б.Баасандорж, Сондуулт багийн малчин П.Түвшинжаргал, Д.Баттулга, М.Батцэнгэл, Хамтын хүч багийн малчин Б.Баатар, П.Энхбаатар, Улаантуг багийн малчин Д.Ганболд, Э.Ганзориг, **аймгийн аварга хадланчаар** Д.Дунхар-Ийчил, **аймгийн аварга саальчнаар** С.Оюунцэцэг нар тодорлоо.

Сумын аварга малчнаар: Баянгол багийн малчин О.Амартүвшин, Б.Ганхуяг, Хамтын хүч багийн малчин Н.Бат-Оргил, М.Эрдэнэбаатар, Н.Батсүх, Сондуулт багийн малчин С.Гантөмөр, Г.Мөнхбат, Улаантуг багийн малчин Д.Наранбаатар, Н.Батбуян, О.Гансүх, Т.Даваадорж, Х.Төмөр-Очир, З.Мөнгөншагай нар тодорлоо. Мөн Хамтын хүч багаас С.Сандаг-Очир, Д.Банди, Улаантуг багаас Н.Батжаргал, Д.Наранбаатар, Сондуулт багаас Д.Баттулга, Л.Түвшин, Т.Дагвасүрэн нарын малчид **шинэ мянгат малчин** болсон байна.

Сумын алдарт уяачаар: Баянгол багаас Д.Дамдиндорж, Г.Уламбаяр, Б.Нэргүй, Ц.Бөхсумъяабазар, Хамтын хүч багаас Я.Гэрэлчулуун, Баз. Батсайхан, Х.Амаржаргал, Т.Ганбаатар, Сондуулт багаас Л.Эрдэнэбаатар, Улаантуг багаас А.Батдэлгэр, Б.Адъяабат, Б.Ганхуяг, Х.Тогоонтөмөр нар сумын алдарт уяач боллоо.

Сумын тэргүүний хадланчаар: Хамтын хүч багийн хадланч Х.Амаржаргал,
Сумын тэргүүний тариаланчаар: Баянгол багийн тариаланч Н.Батбаяр нар тодорлоо.

Улс аймаг, сумын аваргуудын шагналыг аймаг, сум орон нутгийн удирдагууд холбогдох албаны хүмүүс гардууллаа.



МЭДЭЭЛЛИЙН ЦАГИЙГ ХИЙЛЭЭ

Засгийн газрын тогтоолын дагаа 14 хоногт 1 удаа зохион байгуулдаг мэдээллийн цагийг энэ сарын 25-ны өдөр зохион байгууллаа. Мэдээллийн цагаар сумын удирдлагууд цаг үеийн ажил танилцуулж үүрэг даалгаврыг өгч ажилласан. Мөн Нийгмийн даатгалын байцаагч Б.Хорлоожав нийгмийн даатгалын хууль тогтоомжид орсон өөрчлөлт, 2019 онд хийгдэх үйл ажиллагааны талаар, Хөдөө аж ахуйн тасгийн дарга Х.Даваацэрэн мал аж ахуй өвөлжилтийн талаар мэдээг танилцуулсан. Мэдээллийн албан байгууллагуудын дарга эрхлэгч нар, ЗДТГ-ын мэргэжилтнүүд, цагдаа, хэсгийн төлөөлөгч, эрчим хүчний салбарын эрхлэгч нар хамрагддаг.

БАНХАР НОХОЙГ МАЛЧДАД ӨГЛӨӨ

“Ирвэстэй нутгийн ирээдүй” төслийн газраас малчдын малыг ирвэснээс хамгаалах зорилгоор Хамтын хүч багийн 4 өрхөд 6 банхарын гөлгийг өглөө.



ХУУЛЬ СУРТАЛЧЛАХ АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Сумын эрх зүйн сургалт сурталчилгааны ажил зохион байгуулах нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хууль сурталчлах арга хэмжээг энэ сарын 22-ны өдрийн 15 цагт зохион байгууллаа. Нийгмийн даатгалын байцаагч Б.Хорлоожав нийгмийн даатгалын хууль тогтоомжид орсон өөрчлөлт, Улсын бүртгэгч Г.Гантулга

бүртгэлийн мэдээ, улсын бүртгэлийн багц хууль, Мал эмнэлгийн тасгийн дарга Б.Гантулга мал амьтны эрүүл мэндийн тухай хууль, татварын байцаагч С.Тэгшжаргал татварын хуулинд орсон өөрчлөлт, байгаль орчны байцаагч Б.Оюунтүлхүүр гялгар уутны хэрэглээний талаар тус тус сургалт мэдээлэл хийж гарын авлага тараалаа. Уг сургалтанд 57 иргэн оролцлоо.



БОЛОВСРОЛЫН ТАЛААР:

Аймгийн ИТХ-ын төлөөлөгч С.Сүхбаатар, сургуулийн захиргааны санаачлагаар Operation Christmas Child олон улсын байгууллагын Говь-Алтай аймаг дахь салбартай хамтран 204 хүүхдэд бэлэг тарааж, баярлууллаа.



Хүүхдийн оролцооны Сонор, Янзага эко клубын санаачлагаар Шар гэрлээ сүүн болон лед гэрлээр сольлоо.



“Эх хэлээ эрхэмлэе” 2 сарын 25-наас 7 хоногийн аян зарлаад байна. Үүний хүрээнд “Үндэсний хувцастай өдөр” арга хэмжээг зохион байгуулж, анги бүр үндэсний хувцастай загвар үзүүллээ. Ирц 100%-тай байлаа.



2019 оны 2 сарын 25-ны өдөр “Багшийн хөгжил” хөтөлбөрийн хүрээнд багш нарын онолын мэдлэг, хууль эрхзүйн шалгалтыг сургууль дээрээ зохион байгууллаа. Хөндлөнгийн хянагчаар ЗДТГ-ын байгаль орчны байцаагч Б.Оюунтүлхүүр ажиллалаа. Нийт 17 багш хамрагдлаа.

Улсын сэтгэх чадварын 1-р шатны олимпиадыг 7 ангилалаар сургууль дээрээ зохион байгуулж, 2-р шатанд орох сурагчдыг тодрууллаа. 12-р ангийн сурагчдаас ЭЕШ өгөх санал асуулгыг авлаа.

Бага ангийн номын санд 466 ширхэг ном, үзүүлэн ирж, номын санч бага ангийн багш нарт хүлээлгэж өгч, сурагчдад хэрэглүүлж байна. Дунд, ахлах ангийн сурагчдын 104 сурах бичиг шинээр ирж, сурагчдад тарааж өглөө.

Дотуур байрны орчин сайжирч, төлөвлөгөөт хуваарийн дагуу хүүхэд хөгжлийн танхимаар дамжуулан сурагчдыг хөгжүүлэх ажлуудыг зохион байгуулж байна. Мөн сумын цагдаа Мөнх-Эрдэнэтэй хамтран сурагчдад аюулгүй байдал, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл хийлээ. Тасгуудын дунд шилдэг тасаг шалгаруулах уралдаан эхлүүлээд байна.



2019 оны 02 сарын 20-24-ны хооронд Аймгийн аварга шалгаруулах хүүхдийн VI дугаар их наадам зохион байгуулагдлаа. Спортын наадамд нийт 68 сурагч оролцсоноос волейбол, чөлөөт, жү-до бөхийн төрөлд амжилттай оролцлоо. Мөн Хүүхдийн болон насан хүрэгчдийн 2018 оны спортын наадмын дүнгээрээ 1-р байр эзэллээ.



ААШ тэмцээний волейболын төрөлд эрэгтэй баг 2-р байр

1. Г.Мягмардорж 12а
2. Г. Нямбаатар 12а
3. М.Эрдэмтөгс 10а
4. Д.Дамдинбазар 10а
5. Д.Дүүрэнжаргал 11а
6. Т.Хосбаяр 11а
7. Б.Дашдаваа 11а
8. Ц.Бөхсумьяабазар 11а

ААШ тэмцээний чөлөөт бөхийн төрөлд:

1. 11а Б.Дашдаваа 1-р байр
2. 11а Б.Яндагбар 3-р байр
3. 11а Т.Хосбаяр 3-р байр
4. 12а Б.Сүх-Эрдэнэ 3-р байр
5. Г.Алтаншагай 3-р байр
6. 10а Б.Пүрэвсүрэн 2-р байр
7. 9а Б.Түвшинжаргал 3-р байр

ААШ тэмцээний Жү-до бөхийн төрөлд:

1. 5а Б.Лхагвадорж 1-р байр
2. 8а Ж.Ууганбаяр 1-р байр



3. 8а Г.Чулуунтогтох 1-р байр
4. 11а Б.Дашдаваа 1-р байр
5. 8а Д.Доржсэмбэ 2-р байр
6. 4а Н.Төгсбилгүүн 2-р байр
7. 4а А.Алтанбагана 3-р байр
8. 5а Г.Тэмүүлэн 3-р байр
9. 4а Г.Түмэнхүслэн 3-р байр
- 10.5а Т.Түвшинболд 3-р байр
- 11.11а Ц.Бөхсумьяабазар 3-р байр
- 12.9а Г.Отгонбаяр 3-р байр
- 13.10а М.Эрдэмтөгс 3-р байр



Томуу, томуу төст өвчлөл болон улирлын амралт эхэлсэнтэй холбоотойгоор урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулсан. Үүний хүрээнд 248 хүүхдийг үзлэгт хамруулан, 12 ангид өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж тараасан.

Суурь, бүрэн дунд боловсрол эзэмшигчдийн бүртгэлийг мэдээллийн системийн мэдээлэлтний тулгалт хийлээ.

Эрүүл мэндийн үйлчилгээний талаар:

2019 оны 02 сард хэвтэн эмчлүүлсэн нийт үйлчлүүлэгч 10, дуудлага үүнээс ойрын дуудлага 15 ирсэн байна.

Лабораторийн 8 төрлийн шинжилгээг хүнд хийлээ. Үүнд : шээсний ерөнхий шинжилгээ 117 , цусны бүлэг тодорхойлох шинжилгээ 26 хүнд тус тус хийлээ. 02 сард эмнэлгийн дунд мэргэжилтэнгүүд айл өрхөөр явж халдварт бус хүчин зүйлийн судалгаа авч сурталчилгааг хийлээ.

Нялх бага насны хүүхдийн хооллолтын талаар 0-5 настай хүүхэдтэй ээж сургалт сурталчилгааг хийж хооллолтын зөвлөгөөг 30 ээж аавд 4 мэргэжилтэн 12 хүүхдэд өгч дэмжлэгт хяналтыг 4 удаа хийлээ.

Олон найрлагат бичил тэжээлийн холимогийг нийтдээ 54 хүүхдэд 95 ширхэгийг олгож уг бэлдмэлийг хэрхэн хэрэглэх талаарх зөвлөгөөг өглөө. Хөхүүл, жирэмсэн 46 эхэд олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэл 546 ширхэгийг тараалаа.

Хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Томуу, томуу төст өвчний дэгдэлттэй холбоотой хүүхдийн ирц буурсан. 1 ангидаа 5-10 хүүхэд хичээллэж байгаа.

Мэдээлэл бэлтгэсэн:ДАШБХ мэргэжилтэн Д.Ончимэг